

Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын
02-ны өдрийн 160 дугаар тогтоолын хавсралт

НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙН ХОРООНООС ГАРГАСАН
ЗӨВЛӨМЖИЙГ 2025-2031 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Конвенцын холбогдох зүйл, ирүүлсэн зөвлөмжийн дугаар	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хүрэх үр дүн	Хариуцан хэрэгжүүлэх байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
НЭГ.ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ХҮРЭЭНД						
Зорилт 1.1.Хууль тогтоомжийг конвенцод нийцүүлэх, шинэчлэн боловсруулах						
1.	Ерөнхий зарчим ба үүрэг (1-4 дүгээр зүйл)	Дотоодын хууль тогтоомжийг конвенцод нийцэж байгаа эсэхэд үнэлгээ хийх	2025-2029	Нийцүүлэх шаардлагатай хууль тогтоомжийг тодорхойлсон байна	Хууль зүй, дотоод хэргийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Хууль зүйн үндэсний хүрээлэн, Төрийн бус байгууллага
2.	6.а. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусдын нэгэн адил эрх эдлэгч гэж хүлээн зөвшөөрч, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, оюуны бэрхшээлтэй хүмүүс, сэтгэц-нийгмийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй төлөөллийн байгууллагаар нь дамжуулан нягт зөвшилцөн	Улсын Их Хуралд өргөн барьж буй хууль тогтоомжийн төсөлд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, зөрчсөн эсэхийг шалгах “хяналтын хуудас” боловсруулж, батлуулах;	2025-2026	Хууль тогтоомжийг конвенцод нийцүүлсэн байна.	Хууль зүй, дотоод хэргийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Хууль зүйн үндэсний хүрээлэн, Төрийн бус байгууллага
3.	тэдний идэвхтэй оролцоотойгоор дотоодын хууль тогтоомж, бодлогыг конвенцод нийцүүлэн өөрчлөх, хөгжлийн бэрхшээлд үндэслэн ялгаварлан гадуурхалтын эсрэг заалтыг Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан тусгах	Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлан гадуурхахаас хамгаалах, дэмжлэгтэйгээр шийдвэр гаргах эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудлыг судалж, холбогдох хуулийн төслийг боловсруулах	2025-2027	Холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулсан байна.	Хууль зүй, дотоод хэргийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Хууль зүйн үндэсний хүрээлэн, Төрийн бус байгууллага
4.	Хүртээмж (9 дүгээр зүйл)	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	2025	Хуулийн төсөл болон холбогдох журмуудыг батлуулсан байна.	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Сангийн яам, Төрийн бус байгууллага

Д/д	Конвенцын холбогдох зүйл, ирүүлсэн зөвлөмжийн дугаар	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хүрэх үр дүн	Хариуцан хэрэгжүүлэх байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
5.	19.б. Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/251 тоот тушаалыг хэрэгжүүлэх хүрээнд дохионы хэлний үндэсний бодлого, үндсэн чиглэлийг боловсруулахад чиглэсэн төсөв, зорилт, хугацааг тодорхой тусгасан, Дохионы хэлний тухай хуулийг баталж, үйл ажиллагааны тодорхой төлөвлөгөө боловсруулах; шаардлагатай дэмжлэг, туслалцаагаар хангах зохицуулалтыг бий болгох.	Саадгүй байдал, хүртээмжийн тухай анхдагч хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	2025-2026	Хуулийн төсөл болон холбогдох журмуудыг батлуулсан байна.	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Сангийн яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Зам, тээврийн яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
6.		Нөхөн сэргээх, бие даан амьдрах тухай анхдагч хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	2025-2027	Нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчин бүрдсэн байна.	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Сангийн яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Зам, тээврийн яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
7.		Дохионы хэлний тухай анхдагч хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	2025-2027	Дохионы хэлтэй холбогдох эрх зүйн орчныг боловсронгуй болгосон байна.	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсролын яам	Бүх яам, Төрийн бус байгууллага
ХОЁР.ШИНЭ ТӨРЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ТОГТОЛЦОО БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД						
Зорилт 2.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалахад чиглэсэн үндэсний тогтолцоо бүрдүүлэх						
8.	Үндэсний түвшинд хэрэгжүүлэх ба хяналт тавих (33 дугаар зүйл) 68. Хороо нь хараат бус хяналтын тогтолцоог бий болгох, түүнийг Хорооны ажилд оролцуулах талаарх удирдамжийг харгалзан, конвенцын хэрэгжилтэд хяналт тавих төсөв, тодорхой чиг үүрэг бүхий хараат бус хяналтын механизмыг бий болгохыг Оролцогч улсад зөвлөж байна.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн зөрчил, энэ талаарх өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавих чиг үүрэг бүхий хөндлөнгийн хяналтыг төрийн бус байгууллагуудын оролцоотой бүрдүүлэх, шаардлагатай төсвийг шийдвэрлэх	2025-2028	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлж, хөндлөнгийн хяналт тавих тогтолцоо бүрдсэн байна.	Хууль зүй, дотоод хэргийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар	Төрийн бус байгууллага
9.						
10.	70. Хороо нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг бүх бодлого, хөтөлбөрт уялдуулан тусгах чиг үүргийг хэрэгжүүлэхэд хангалттай эрх мэдэл, хүний нөөц, төсвийн хуваарилалт бүхий нэг	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд болон салбар зөвлөл, түүний ажлын албаны эрх зүйн байдлыг сайжруулах, үйл ажиллагаанд шаардлагатай төсвийг жил бүрийн улс, орон нутгийн төсөвт тусгах	2025-2031	Зөвлөл тогтмол, байнгын ажиллагаатай болсон байна.	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Төрийн бус байгууллага

Д/д	Конвенцын холбогдох зүйл, ирүүлсэн зөвлөмжийн дугаар	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хүрэх үр дүн	Хариуцан хэрэгжүүлэх байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
11.	буюу хэд хэдэн бүтцийг Засгийн газрын хүрээнд байгуулахыг Оролцогч улсад зөвлөж байна.	Салбар бүрд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахад чиглэсэн төсөвтэй болоход чиглэсэн зохицуулалтыг батлан хэрэгжүүлэх	2025	Нийгмийн оролцоог нэмэгдүүлэх боломж бүрдсэн байна.	Сангийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Бүх яам, Төрийн бус байгууллага
Зорилт 2.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах салбарын тоон мэдээллийг хүний эрхийн загварт тулгуурлан боловсруулдаг болох						
12.	С.Тусгай үүрэг Статистик болон мэдээлэл цуглуулах (31 дүгээр зүйл) 62.а. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн мэдээллийг нас, хүйс, бэлгийн чиг баримжаа, арьсны өнгө, үндэс угсаа, орлого, шилжилт хөдөлгөөний байдал, боловсролын түвшин, ажил эрхлэлтийн байдал, оршин суугаа газраар нь ангилан цуглуулах тогтолцоо, журмыг яаралтай боловсруулах.	Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангиллыг нэвтрүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах	2025-2031	Төрийн үйлчилгээний хүртээмж сайжирсан байна.	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам, Боловсролын яам	Төрийн бус байгууллага
13.	чиг баримжаа, арьсны өнгө, үндэс угсаа, орлого, шилжилт хөдөлгөөний байдал, боловсролын түвшин, ажил эрхлэлтийн байдал, оршин суугаа газраар нь ангилан цуглуулах тогтолцоо, журмыг яаралтай боловсруулах.	Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын аргачлалаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аж байдлын судалгаа (MDS-Model disability survey)-г хийх ажлыг зохион байгуулах	2025-2027	Нарийвчилсан тоон мэдээтэй болсон байна.	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	Үндэсний статистикийн хороо, Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Төрийн бус байгууллага
14.	62.б. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хэрэгжүүлэхэд тулгарч буй саад тотгорыг тодорхойлох зорилгоор тэдний эрхийн талаар тогтмол судалгаа явуулахад хөрөнгө хуваарилах	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээллийн нэгдсэн санг байгуулах	2025-2027	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх мэдээллийн нэгдсэн сантай болсон байна.	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Үндэсний статистикийн хороо	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Төрийн бус байгууллага
15.		Хөгжлийн бэрхшээлийн талаарх нэр томьёоны тайлбар толь бичгийг боловсруулж, хэрэглээнд нэвтрүүлэх	2025	Нэр томьёоны албан ёсны тайлбартай болсон байна.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Боловсролын яам	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Шинжлэх ухааны академи, Төрийн бус байгууллага
2.3.Шинэ төрлийн үйлчилгээ нэвтрүүлж, хүний нөөцийг бэлтгэх						
16.	Бие даан амьдрах болон тухайн оршин суугаа орчиндоо байх эрх (19 дүгээр зүйл) 40.б. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн оролцоог хангах, бие даан амьдрах боломжид чиглэсэн нийгэм, хамт олонд түшиглэсэн үйлчилгээнүүдийг бий болгох, нэмэгдүүлэх;	Хувийн туслах үйлчилгээг үндэсний хэмжээнд хөгжүүлэх	2025-2031	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоо нэмэгдсэн байна.	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Сангийн яам	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Төрийн бус байгууллага
17.	40.в. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгэм, хамт олны дунд	Дохионы хэлмэрчийг бэлтгэх тогтолцоог бүрдүүлж, дохионы хэлмэрчийн үйлчилгээг бэхжүүлэх	2025-2031	Дохионы хэлмэрч, орчуулагчийг бэлтгэсэн байна.	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсролын яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Төрийн бус байгууллага

Д/д	Конвенцын холбогдох зүйл, ирүүлсэн зөвлөмжийн дугаар	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хүрэх үр дүн	Хариуцан хэрэгжүүлэх байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
18.	бие даан амьдрахад нь шаардлагатай хувийн туслах бэлтгэх сургалт, дэмжлэг, үйлчилгээг сайжруулах, эрчимжүүлэх, мөн хувийн туслахын цалинг нэмэгдүүлэх	Хөгжлийн хоцрогдол, хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх олон улсын хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2025-2031	Олон улсад туршигдсан гурваас доошгүй хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Төрийн бус байгууллага
19.		Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах салбарт хомсдолтой байгаа хүний нөөцийн талаарх нэгдсэн судалгаа хийж, тасралтгүй бэлтгэх ажлыг зохион байгуулах	2025-2031	Хүний нөөцийн хомсдол буурсан байна.	Боловсролын яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам	Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагууд, Төрийн бус байгууллага
20.		Туслах технологийн үндэсний стратегийг батлан хэрэгжүүлэх	2025-2027	Үндэсний стратегийг баталсан байна.	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам, Боловсролын яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Харилцаа, холбооны зохицуулах хороо	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Төрийн бус байгууллага
ГУРАВ.ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН МЭДЛЭГ, ОЙЛГОЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ХҮРЭЭНД						
Зорилт 3.1.Сургалт зохион байгуулах, эрх зүйн орчныг бүрдүүлэх						
21.	Бие даан амьдрах болон тухайн оршин суугаа орчиндоо байх эрх (19 дүгээр зүйл) 40.а. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс амьдралын хэв маяг, амьдрах орчноо өөрөө тодорхойлох, сонгох эрх, хүчээр тусгай нөхцөл байдалд амьдрахгүй байх эрх зэргийг хөхүүлэн дэмжиж, тусгаарлах бус нийгэм хамт олны дунд хамрагдахын ач холбогдлын талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг оролцуулан тусгах;	Төлөвлөгөөний 13-т тусгасан судалгааны үр дүнд үндэслэн Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамруулсан үндэсний стратегийг боловсруулан, салбар, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлэх	2025-2031	Стратегитай болсон байна.	Бүх яам	Төрийн бус байгууллага

Д/д	Конвенцын холбогдох зүйл, ирүүлсэн зөвлөмжийн дугаар	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хүрэх үр дүн	Хариуцан хэрэгжүүлэх байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
22.	Мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх (8 дугаар зүйл) 18.б. Хөгжлийн бэрхшээлтэй бүх хүмүүсийн нэр төр, авьяас билиг, хувь нэмрийг хүндэтгэхийг дэмжих зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн идэвхтэй оролцоотойгоор Бодлого боловсруулагчид, шүүх эрх мэдэл, хууль сахиулах байгууллагын ажилтнууд, хэвлэл мэдээлэл, улс төрчид, сурган хүмүүжүүлэгчид, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөө, тэдгээртэй хамтран ажилладаг мэргэжилтнүүд болон олон нийтэд зориулсан хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн загвар, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн талаар тогтмол сургалт болон ойлголт нэмэгдүүлэх модулиудыг боловсролын бүх түвшинд хүртээмжтэй бүхий л хэлбэрээр нэвтрүүлэх нь зүйтэй. Хороо цаашид Оролцогч улсыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудтай хамтран хөгжлийн бэрхшээлийн хүний эрхийн загварыг ойлгуулж, хэрэгжүүлэхэд төрийн байгууллагын бүх албан тушаалтан, түүнчлэн олон нийтэд чиглэсэн сургалтын санал санаачилгыг боловсруулж, хэрэгжүүлэхийг уриалж байна.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхэд суурилсан сургалтын багц модуль боловсруулж, хүний нас, хөгжлийн онцлогт нийцсэн ялгаатай байдлын талаар бодлого боловсруулагч, төрийн албан хаагчдад зориулсан сургалт зохион байгуулах	2025-2031	Хөгжлийн бэрхшээлийн ойлголт, мэдлэг өгөх суурь сургалтын агуулгатай болсон байна.	Боловсролын яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Сургагч багш нарын баг, Төрийн бус байгууллага
23.		Төрийн байгууллага, аж ахуйн нэгж байгууллагын албан хаагчдад хөгжлийн бэрхшээлийн талаарх сургалтыг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулах	2025-2031	Сургалтыг тасралтгүй, нэгдсэн төлөвлөгөөний дагуу зохион байгуулах боломж бүрдсэн байх, сургалтын түвшин тогтоодог байх	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Бүх яам	Бүх салбарын төрийн байгууллага, Төрийн бус байгууллага
24.		Хөгжлийн бэрхшээлийн талаарх зөв ойлголт, мэдлэг олгоход чиглэсэн мэдээллийг олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар боловсруулж түгээх	2025-2031	Хөгжлийн бэрхшээлийн талаарх олон нийтийн мэдлэг, ойлголт нэмэгдсэн байна. Үр дүнг үнэлэх түүвэр судалгаа хийсэн байна.	Бүх яам	Олон улсын байгууллага, бүх салбарын төрийн байгууллага, Төрийн бус байгууллага

ДӨРӨВ.БОЛОВСРОЛЫН ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ХҮРЭЭНД

Зорилт 4.1.Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг боловсролд тэгш хамруулах, хэрэгцээ шаардлагад нь нийцсэн дэмжлэгийн үйлчилгээ бий болгох

25.	Боловсрол (24 дүгээр зүйл) 48.а. Боловсролын бүх түвшинд тэгш хамруулах соёлыг дэмжих, түүний дотор боловсролын шаардлага, хэрэгцээт тохируулга, хэрэглэгдэхүүн зэргийг тодорхойлох хүний эрхэд суурилсан ганцаарчилсан үнэлгээ	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, салбарт дутагдалтай байгаа хүний нөөцийн судалгааг гаргаж, шаардлагатай мэргэжилтнийг бэлтгэх төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх	2025-2031	Боловсролын салбарын хүний нөөцийн хомсдол буурсан байна.	Боловсролын яам, Эрүүл мэндийн яам, Гадаад харилцааны яам	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Төрийн бус байгууллага
26.		Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн үнэлгээнд тулгуурлан боловсролын үйлчилгээнд бүрэн	2025-2031	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн	Боловсролын яам, Боловсролын ерөнхий газар	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам,

Д/д	Конвенцын холбогдох зүйл, ирүүлсэн зөвлөмжийн дугаар	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хүрэх үр дүн	Хариуцан хэрэгжүүлэх байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
	хийдэг байхыг оролцуулан, зохих стратеги, төсвийн эх үүсвэртэй тэгш хамруулан сургах боловсролын цогц бодлогыг боловсруулах, мөн тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр ердийн багш, боловсролын салбарын ажилтнуудад зохих сургалт явуулах;	хамруулах хувилбарт, уян хатан хөтөлбөр, ганцаарчилсан, тусгай хөтөлбөрөөр суралцуулах зэрэг хувилбарт загваруудыг өргөжүүлэх, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний чанарыг сайжруулах		боловсролын үйлчилгээнд хамрагдалт нэмэгдсэн байна.		Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Төрийн бус байгууллага
27.	боловсролын салбарын ажилтнуудад зохих сургалт явуулах;	"Монгол дохионы хэл"-ний хичээлийг багш, хүний нөөц бэлтгэдэг их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгах	2025-2027	Хөтөлбөр нэвтрүүлсэн байна.	Боловсролын яам, Боловсролын ерөнхий газар	Төрийн бус байгууллага
28.	48.б. Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад нөхөн туслах хэрэгслээр хангах, зааж, багшлахад ашиглах хэрэглэгдэхүүн, сургалтын хэрэглэгдэхүүнийг сонголттой, хүртээмжтэй хэлбэрээр, түүний дотор хялбар унших, харилцааны хэрэгсэл, туслах болон мэдээллийн технологи зэрэг харилцааны горим, хэрэгслээр хангах.	Ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг тэгш хамруулан сургахад чиглэсэн сургалт, хяналт, үнэлгээний ажлыг зохион байгуулах	2025-2027	Хяналт, үнэлгээний ажлыг зохион байгуулж, нэгдсэн зөвлөмж хүргүүлсэн байна.	Боловсролын яам, Боловсролын ерөнхий газар	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Төрийн бус байгууллага
29.	48.в. Ердийн багш, боловсролын салбарын ажилтнуудыг тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр сургах, хөгжлийн бэрхшээлийн хүний эрхийн загварын талаарх тэдний мэдлэгийг дээшлүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дээд боловсрол, мэргэжлийн боловсрол, насанд хүрэгчдийн боловсрол, насан туршийн боловсролыг ялгаварлан гадуурхалтаас ангид бусадтай нэгэн адил тэгш авах боломжийг баталгаажуулах.	Насан туршийн боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөр, агуулга хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн хэрэгцээ, шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт, шалгалтын ажил зохион байгуулах	2025-2026	Хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж, нэгдсэн зөвлөмж хүргүүлсэн байна.	Боловсролын яам, Боловсролын ерөнхий газар	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Төрийн бус байгууллага
30.		Боловсролын орчин дахь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн хэрэгцээт тохируулгыг тодорхойлж, туслах хэрэгсэл болон сургалтын материал, мэдээлэл харилцааны хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулах	2025-2031	Боловсролын байгууллагад тохируулга бүхий орчин бүрдсэн байна.	Боловсролын яам, Боловсролын ерөнхий газар	Аймаг, нийслэлийн Засаг дарга
31.		Хүний эрхэд суурилсан ганцаарчилсан үнэлгээний ажлыг зохион байгуулж, тэгш хамруулан сургах боловсролын цогц бодлогыг боловсруулах	2025-2027 2025-2031	Бодлого, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг баталсан байна.	Боловсролын яам, Боловсролын ерөнхий газар	Аймаг, нийслэлийн Засаг дарга
32.		Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй суралцагчдад хос хэлний боловсрол олгох ажлыг эрчимжүүлэх	2025-2028	Хос хэлний боловсрол олгох сургалтын хөтөлбөрийг баталсан байна.	Боловсролын яам, Боловсролын ерөнхий газар	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Төрийн бус байгууллага
33.		Оюуны болон сэтгэцийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн оролцоог	2025-2028	Шилжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.	Боловсролын яам, Боловсролын ерөнхий газар	Хөгжлийн бэрхшээлтэй хүний

Д/д	Конвенцын холбогдох зүйл, ирүүлсэн зөвлөмжийн дугаар	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хүрэх үр дүн	Хариуцан хэрэгжүүлэх байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
		нэмэгдүүлэхэд чиглэсэн шилжилтийн хөтөлбөр хэрэгжүүлэх				хөгжлийн ерөнхий газар, Төрийн бус байгууллага
ТАВ.ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ХҮРЭЭНД						
5.1.Эрүүл мэндийн үйлчилгээг хүртээмжтэйгээр авах боломж, нөхцөлийг бүрдүүлэх						
34.	Эрүүл мэнд (25 дугаар зүйл) 50. Хороо нь Конвенцын 25 дугаар зүйл болон Тогтвортой хөгжлийн зорилтуудын 3.7, 3.8 дугаар зорилтуудын хоорондын уялдаа холбоог харгалзан өмнөх зөвлөмжөө дахин сануулж, хөгжлийн бэрхшээлтэй бүх хүмүүст эрүүл мэндийн үйлчилгээ, ялангуяа бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ, эх, хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээг тэр тусмаа хөдөөгийн, алслагдсан бүс нутагт хүртээмжтэй байлгах арга хэмжээг авахыг Оролцогч улсад зөвлөж байна. Хорооноос мөн хөгжлийн бэрхшээлтэй бүх хүмүүс аливаа хэлбэрийн согог бэрхшээлээсээ үл хамааран мэдээлэл авсны үндсэн дээр зөвшөөрлөө чөлөөтэй өгөх эрхтэй болохыг нь баталгаажуулсан арга хэмжээ авахыг Оролцогч улсад зөвлөж байна.	Уналт таталт, булчин суллах эмийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, холголт цооролтын эсрэг хэрэглэх эм бэлдмэл, эмчилгээг сайжруулах	2025-2031	Шаардлагатай үйлчилгээ бий болсон байна.	Эрүүл мэндийн яам	Харьяа байгууллагууд, Төрийн бус байгууллага
35.		Урт хугацааны сэргээн засах эмчилгээ, үйлчилгээний талаарх дүрэм, журмыг шинэчлэх	2025-2031	Эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна.	Эрүүл мэндийн яам	Харьяа байгууллагууд, Төрийн бус байгууллага
36.		Хөгжлийн бэрхшээлтэй хүний нөхөн үржихүйн эрхэд үнэлгээ хийж, эрхийг хангахад чиглэсэн шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх	2025-2031	Нөхөн үржихүйн эрхийн хэрэгжилт сайжирсан байна.	Эрүүл мэндийн яам	Харьяа байгууллагууд, Төрийн бус байгууллага
37.		Монгол Улсад оношлох боломж хязгаарлагдмал тархины төрлийн эмгэг, өвчнийг гадаадад оношлуулах боломж, нөхцөлийг бүрдүүлэх	2025-2031	Олон улсын түвшинд хамтын ажиллагааг бэхжүүлсэн байна.	Эрүүл мэндийн яам	Харьяа байгууллагууд, Төрийн бус байгууллага
38.		Жирэмсэн эхчүүдэд зориулсан нярайн шарлалт болон бусад төрлийн хожуу үеийн хөгжлийн бэрхшээл үүсэх шалтгааныг таниулах сургалт, нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулах	2025-2031	Хөгжлийн бэрхшээл үүсэх шалтгааны талаар ойлголт, мэдлэгтэй болсон байна.	Эрүүл мэндийн яам	Харьяа байгууллагууд, Төрийн бус байгууллага
39.		Бүх нийтийн эрүүл мэндийг сайжруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тогтмол хамруулах	2025-2031	Иргэдийг үйлчилгээнд тэгш хамруулсан байна.	Эрүүл мэндийн яам	Харьяа байгууллагууд, Төрийн бус байгууллагаС
40.		Хөгжлийн бэрхшээлтэй хүн өөрийн оршин байгаа газраасаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүртээмжтэйгээр түргэн, шуурхай авах боломжийг бүрдүүлэх	2025-2031	Орчны болон үйлчилгээний хүртээмж сайжирсан байна.	Эрүүл мэндийн яам	Харьяа байгууллагууд, Төрийн бус байгууллага

Д/д	Конвенцын холбогдох зүйл, ирүүлсэн зөвлөмжийн дугаар	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хүрэх үр дүн	Хариуцан хэрэгжүүлэх байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
ЗУРГАА.ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ САЙЖРУУЛАХ ХҮРЭЭНД						
Зорилт 6.1.Шинэлэг үйлчилгээ, үйл ажиллагаа нэвтрүүлэх						
41.	Ажил, хөдөлмөр эрхлэлт (27 дугаар зүйл) 54.а. Нээлттэй хөдөлмөрийн зах зээл дээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог хаасан, эсхүл хязгаарласан бүхий л ялгаварлалын шинжтэй хууль тогтоомжийг хүчингүй болгох, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, оюуны болон сэтгэц-нийгмийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөрлөх эрхийг хангах үр дүнтэй арга хэмжээ авах, түүнчлэн ажлын зар, ажилд авах үйл явц, шаардлагатай тохируулгаар хангах, давтан сургах, албан тушаал дэвшихэд болон ажил, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой бусад эрхээ эдлэх явцад ялгаварлан гадуурхахтай тэмцэх арга хэмжээ мөн авч хэрэгжүүлэх;	Мэргэжлийн боловсролын сургуулийн хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй холбогдох агуулга нэмж тусган хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тэгш хамруулах	2025-2027	Мэргэжлийн боловсролд хамрагдсан байна.	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсролын яам, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар, Төрийн бус байгууллага
42.	54.б. Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулж, төрийн болон хувийн хэвшилд ажиллагсад ажлын байрандаа шаардлагатай тохируулгаар хангагдах эрхтэй болохыг хүлээн зөвшөөрч, баталгаажуулах;	Ажлын байрны дадлагажуулагчийг тасралтгүй бэлтгэж, тогтвортой ажиллуулахад чиглэсэн эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлж, хэрэгжилтийг хангах	2025-2031	Холбогдох хууль, журам батлагдсан байна.	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Төрийн бус байгууллага
43.	54.в. Нээлттэй хөдөлмөрийн зах зээл дээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ажиллаж, хөдөлмөрлөх боломжтой байх, ялангуяа ажлын зар, ажилд авах үйл явц, шаардлагатай тохируулгаар хангагдах, давтан сургах, албан тушаал дэвших, бизнес эрхлэх болоод бусад ажиллах, хөдөлмөрлөх эрхүүдээ эдлэхтэй холбогдуулан хүртээмжтэй ажлын	Оюун, сэтгэцийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөрт бэлтгэх шилжилтийн хөтөлбөр хэрэгжүүлэх	2025-2031	Хөтөлбөр хэрэгжүүлсэн байна.	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Төрийн бус байгууллага
44.		Оюуны бүтээл туурвидаг хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх	2025-2031	Арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Төрийн бус байгууллага
45.		Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч буй иргэнд цахимаар, гэрээс, зайнаас ажиллах боломж бүрдүүлэх	2025-2027	Холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулсан байна.	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хууль зүй, дотоод хэргийн яам	Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Төрийн бус байгууллага
46.		Хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих	2025-2031	Хөдөлмөр эрхлэлтийн хувь өссөн байна.	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	Сангийн яам, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Төрийн бус байгууллага

Д/д	Конвенцын холбогдох зүйл, ирүүлсэн зөвлөмжийн дугаар	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хүрэх үр дүн	Хариуцан хэрэгжүүлэх байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
47.	байрны орчноор хангагдах, түүний дотор тусгаарласан байгууллагад амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, оюуны бэрхшээлтэй хүмүүс, сонсголын бэрхшээлтэй хүмүүс, сэтгэц-нийгмийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст мөн хамаарна.	Халамжийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хөгжүүлэх	2025-2031	Оюуны болон сэтгэцийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр арга хэмжээ (хөтөлбөр) хэрэгжүүлсэн байна.	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	Сангийн яам, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Төрийн бус байгууллага
48.		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн төвд болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагад мэдээлэл өгч, сайн туршлага түгээх арга хэмжээг тогтмолжуулах	2025-2031	Аж ахуйн нэгж, байгууллагад мэдээлэл өгч, сайн туршлага түгээсэн байна.	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Төрийн бус байгууллага
49.		Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрт зуучлах үйлчилгээг Төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх	2025-2031	Хөдөлмөрт зуучлах төвийг аймаг, дүүрэгт нэвтрүүлсэн байна.	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар, Төрийн бус байгууллага
50.		Ажиллуулбал зохих хувь хэмжээ болон түүний төлбөрийг Монгол Улсын нөхцөлд нийцүүлж өөрчлөх судалгаа хийх	2025-2027	Судалгаа хийж, санал боловсруулсан байна.	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар, Төрийн бус байгууллага
51.		Тохируулгатай ажлын байрны журам, тохирох хэрэгслийн жагсаалтыг батлан хэрэгжүүлэх	2025-2027	Журам, жагсаалт баталсан байна.	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн бус байгууллага
52.		Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийх ажлыг тогтмол зохион байгуулах	2025-2031	Жил бүр хэрэгжилтэд хяналт, шалгалт хийсэн байна.	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Төрийн бус байгууллага
53.		Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	2025-2031	Хөтөлбөрийн хүрээг өргөжүүлсэн байна.	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын	Хөгжлийн бэрхшээлтэй хүний

Д/д	Конвенцын холбогдох зүйл, ирүүлсэн зөвлөмжийн дугаар	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хүрэх үр дүн	Хариуцан хэрэгжүүлэх байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
		хөтөлбөрийн хүрээг өргөжүүлж, үйл ажиллагааг оновчтой тогтоох			яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	хөгжлийн ерөнхий газар, Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар, Төрийн бус байгууллага
54.		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төрийн албанд тогтвортой ажиллуулахад чиглэсэн арга хэмжээ хэрэгжүүлж, төрийн өндөр албан тушаалд дэвшин ажиллахад ур чадвар олгох сургалтад хамруулах	2025-2028	Төрийн албанд бэлтгэх хөтөлбөр хэрэгжүүлсэн байна.	Төрийн албаны зөвлөл, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Төрийн бус байгууллага
ДОЛОО.СААДГҮЙ БАЙДАЛ, ХҮРТЭЭМЖТЭЙ ОРЧНЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ХҮРЭЭНД						
Зорилт 7.1.Хүртээмжийг олон нийтэд таниулах, барилга, байгууламж, нийтийн тээвэр, зам, замын байгууламж, мэдээ, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх						
55.	Хүртээмж (9 дүгээр зүйл) 20.в. Хөдөө орон нутаг, хот суурин газрын хаана ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг өөрийг нь хүрээлэн буй биет орчин, тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо, тухайлбал харилцаа холбооны технологи, систем болон нийтэд нээлттэй үйлчлэх буюу зориулагдсан бусад төрлийн байгууламж үйлчилгээг бусдын нэгэн адил хүртэх, ашиглах явдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх; 20.г. Цагдаа, эрүүл мэндийн тогтолцоонд хүртээмжтэй байдлыг хангах механизм, удирдамжийг батлан нэвтрүүлэх;	Хөгжлийн бэрхшээлтэй хүний түгээмэл загварт нийцсэн тоног, төхөөрөмж, тусгай хэрэгслийг олон нийтэд таниулах, түүний хэрэглээг нэмэгдүүлэх, үйлчилгээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах	2025-2031	Түгээмэл загварыг олон нийтэд таниулсан загварыг бий болгоно.	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам	Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар, Төрийн бус байгууллага
56.	Хөгжлийн бэрхшээлтэй бүх хүмүүст, ялангуяа харааны бэрхшээлтэй хүмүүст боловсролын байгууллагын болон гэрийн орчин, төрийн болон хувийн цахим хуудас, гар утасны програмуудаар цахим технологид түгээмэл загвараар нэвтрэх боломжоор хангах.	Инженер, мэдээлэл технологи, зам, замын байгууламжийн чиглэлээр суралцаж буй оюутныг түгээмэл загвар, хөгжлийн бэрхшээлийн чиглэлийн сургалтад тогтмол хамруулах	2025-2031	Мэдлэг, ойлголт сайжирсан байна.	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Зам, тээврийн яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Төрийн бус байгууллага
57.	Хөгжлийн бэрхшээлтэй бүх хүмүүст, ялангуяа харааны бэрхшээлтэй хүмүүст боловсролын байгууллагын болон гэрийн орчин, төрийн болон хувийн цахим хуудас, гар утасны програмуудаар цахим технологид түгээмэл загвараар нэвтрэх боломжоор хангах.	Барилгын болон замын инженер, веб хөгжүүлэлтийн мэргэжилтэн бэлтгэх чиглэлээр шаардлага хангасан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжиж сургах	2025-2031	Хөгжлийн бэрхшээлтэй мэргэжилтэн бэлтгэсэн байна.	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Зам, тээврийн яам, Боловсролын яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Төрийн бус байгууллага
58.	Хөгжлийн бэрхшээлтэй бүх хүмүүст, ялангуяа харааны бэрхшээлтэй хүмүүст боловсролын байгууллагын болон гэрийн орчин, төрийн болон хувийн цахим хуудас, гар утасны програмуудаар цахим технологид түгээмэл загвараар нэвтрэх боломжоор хангах.	Монгол Улсын барилга, байгууламж, замын хүртээмжийн байдалд үнэлгээ хийж үнэлж, гэрчилгээжүүлж, цахим зураглал гаргах, нийтийн зориулалттай барилга, байгууламжид оюуны болон сэтгэцийн бэрхшээлтэй хүнд хялбар	2025-2027	Хүртээмжтэй байгууламжийн мэдээлэлтэй болсон байна.	Зам, тээврийн яам Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам,	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний

Д/д	Конвенцын холбогдох зүйл, ирүүлсэн зөвлөмжийн дугаар	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хүрэх үр дүн	Хариуцан хэрэгжүүлэх байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
		уншигдах болон зурган мэдээллийг нэвтрүүлэх			Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам	хөгжлийн ерөнхий газар, Төрийн бус байгууллага
59.		Хөгжлийн бэрхшээлтэй хүнд саадгүй, хүртээмжтэй орчин нөхцөл бүрдүүлсэн жишиг хороо, сумтай болох	2025-2031	Загвар болгон бусад хороо, сумдуудад таниулсан байна.	Аймаг, нийслэлийн засаг даргын тамгын газар, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Зам, тээврийн яам	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Төрийн бус байгууллага
60.		Олон улсын мэдээллийн хүртээмжийн WCAG2.0 болон H.702 стандартыг нэвтрүүлж, мэдээллийн болон танин мэдэхүйн хөтөлбөрт дохионы хэл болон хадмал, дуут тайлбарыг ашигладаг хүртээмжтэй телевизийн тоог нэмэгдүүлэх	2025-2031	Хүртээмжтэй телевизийн тоо нэмэгдсэн байна.	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Харилцаа холбооны зохицуулах хороо	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Төрийн бус байгууллага
61.		Нийтийн тээврийн парк шинэчлэлээр дамжуулан хүртээмжтэй автобусны тоог нэмэгдүүлэх	2025-2031	Нийтийн тээвэр хүртээмжтэй болсон байна.	Зам, тээврийн яам Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Төрийн бус байгууллага
62.		Зам, замын байгууламжийн хүртээмжийг сайжруулах чиглэлээр явган зорчигчийн гэрлэн дохио дуут дохиотой болох, харааны бэрхшээлтэй хүний хөтөч замыг нэмэгдүүлэх, стандартад нийцүүлэх, явган замыг тэргэнцэртэй иргэдэд саадгүй болгох	2025-2027	Дуут гэрлэн дохио, хөтөч зам, замын байгууламжийн хүртээмж нэмэгдсэн байна.	Зам ,тээврийн яам Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	Харьяа байгууллагууд, Төрийн бус байгууллага

НАЙМ. ХЯНАЛТЫН ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛАХ ХҮРЭЭНД

Д/д	Конвенцын холбогдох зүйл, ирүүлсэн зөвлөмжийн дугаар	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хүрэх үр дүн	Хариуцан хэрэгжүүлэх байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
63.	Үндэсний түвшинд хэрэгжүүлэх ба хяналт тавих (33 дугаар зүйл) 66. Тодорхой, ил тод бөгөөд олон нийтийн оролцоог хангасан сонгон шалгаруулалт, томилгооны үйл явцыг албажуулах, мөн Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын бүрэлдэхүүнд олон талт байдал, олон ургалч төлөөллийг нэмэгдүүлэхээс гадна үр дүнтэй, хараат бусаар ажиллаж, бүрэн эрхээ Парисын зарчмуудад бүрэн нийцүүлэн хэрэгжүүлэх	Албан тушаалын сонгон шалгаруулалт, томилгоог нээлттэй, ил тод зохион байгуулж, мэдээлдэг болох	2025-2031	Сонгон шалгаруулалт болон томилгоог нээлттэй, ил тод зохион байгуулж, мэдээлдэг болсон байна.	Төрийн албаны зөвлөл	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар, Төрийн бус байгууллага
64.	Хүний эрхийн үндэсний комиссын бүрэлдэхүүнд шаардлага хангасан хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулах боломж, нөхцөлийг бүрдүүлэх	Хүний эрхийн үндэсний комиссын бүрэлдэхүүнд шаардлага хангасан хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулах боломж, нөхцөлийг бүрдүүлэх	2025-2026	Хүний эрхийн үндэсний комиссын гишүүнээр хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулах эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна.	Хууль зүй, дотоод хэргийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Хүний эрхийн үндэсний комисс, Төрийн бус байгууллага
ЕС. БУСАД ЭРХИЙГ ХАНГАХ ХҮРЭЭНД						
65.	Амьжиргааны хүрэлцэхүйц түвшин, нийгмийн хамгаалал (28 дугаар зүйл) 56.а. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн хамгааллын болон ядуурлыг бууруулах тогтолцоог бэхжүүлж, инфляцын түвшин, амьжиргааны доод түвшнийг харгалзан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдгээрийн төлөөллийн байгууллагатай нягт зөвшилцөж, идэвхтэй оролцуулсны үндсэн дээр тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх; хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан хүртээмжтэй, орлогод нийцсэн орон сууцны хөтөлбөрүүдийг нэвтрүүлж, эдгээр хөтөлбөрүүдэд төсвөөс хангалттай санхүүжилт олгох	Орлогод нийцсэн орон сууцны хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг уян хатан нөхцөлөөр хамруулах	2025-2031	Орон байрны нөхцөл сайжирсан байна.	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Төрийн бус байгууллага
66.	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдгээрийн төлөөллийн байгууллагатай нягт зөвшилцөж, идэвхтэй оролцуулсны үндсэн дээр тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх; хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан хүртээмжтэй, орлогод нийцсэн орон сууцны хөтөлбөрүүдийг нэвтрүүлж, эдгээр хөтөлбөрүүдэд төсвөөс хангалттай санхүүжилт олгох	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг үе шаттайгаар нэмэгдүүлэх	2025-2031	Тэтгэвэр, тэтгэмжийг үе шаттайгаар нэмсэн байна.	Сангийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар
67.	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдгээрийн төлөөллийн байгууллагатай нягт зөвшилцөж, идэвхтэй оролцуулсны үндсэн дээр тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх; хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан хүртээмжтэй, орлогод нийцсэн орон сууцны хөтөлбөрүүдийг нэвтрүүлж, эдгээр хөтөлбөрүүдэд төсвөөс хангалттай санхүүжилт олгох	Хөдөө орон нутагт амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх	2025-2031	Олон улсын байгууллагатай хамтран арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Зам, тээврийн яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Төрийн бус байгууллага
68.	Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрхийг хангах, оролцоог нь нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх	Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрхийг хангах, оролцоог нь нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх	2025-2031	Олон улсын байгууллагатай хамтран арга		Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар, Хөгжлийн

Д/д	Конвенцын холбогдох зүйл, ирүүлсэн зөвлөмжийн дугаар	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хүрэх үр дүн	Хариуцан хэрэгжүүлэх байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
				хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Олон улсын байгууллага, Төрийн бус байгууллага
69.	Соёлын амьдралд оролцох, чөлөөт цаг, амралтаа өнгөрүүлэх, спортоор хичээллэх (30 дугаар зүйл) 60.а. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст соёлын бүтээл, телевизийн нэвтрүүлэг, кино, театр болон бусад соёлын арга хэмжээг хүртээмжтэй хэлбэрээр хүртэх, соёлын тоглолт, үйлчилгээ, тухайлбал театр, музей, кино театр, номын сан, аялал жуулчлалын үйлчилгээ, спортын үйлчилгээний газруудад нэвтрэн орж, үзэх боломжийг нэмэгдүүлэх;	Соёлын болон спортын үйлчилгээ үзүүлдэг байгууллагын үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй болгож, саадгүй нэвтэрч үйлчилгээ авах, тэгш хамрагдах боломжоор хангах, спорт, урлагаар хичээллэх боломж, нөхцөлийг бүрдүүлэх, улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй урлаг, соёлын арга хэмжээг дохионы хэлмэрч болон тайлбартайгаар хүргэх	2025-2031	Саадгүй нэвтэрч үйлчилгээ авах, спорт, урлагаар хичээллэх боломж, нөхцөлийг бүрдүүлсэн байна.	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Биеийн тамир, спортын улсын хороо	Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар, Төрийн бус байгууллага
70.	Хөгжлийн бэрхшээлтэй хүн олон улсын болон дотоодын аливаа спортын болон урлаг, соёлын тэмцээн, уралдаанд оролцох боломж, нөхцөлийг нэмэгдүүлэх, дэмжих		2025-2031	Тэмцээний тоо нэмэгдсэн байна.	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Биеийн тамир, спортын улсын хороо	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Төрийн бус байгууллага
71.	60.б. Хараагүй, харааны бэрхшээлтэй эсвэл хэвлэмэл бүтээл уншихад бэрхшээлтэй хүмүүст хэвлэн нийтлэгдсэн бүтээлийг хүртээмжтэй болгох тухай Марракешийн гэрээг үр дүнтэй хэрэгжүүлэх;	Паралимп, Дифлимп, Тусгай олимп, Ази тивийн наадмуудын нээлт, хаалт, тэмцээний үйл явцыг шууд нэвтрүүлгээр хүргэх	2025-2031	Шууд нэвтрүүлгээр хүргэсэн тэмцээний тоо нэмэгдсэн байна.	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Харилцаа холбооны зохицуулах хороо	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар
72.	60.в. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд бусадтай нэгэн адил тэгш эрхтэйгээр соёлын амьдрал, чөлөөт цаг, амралтаа өнгөрөөх, спортоор хичээллэх эрхээ эдлэх боломжоор хангахад хүчин чармайлтаа нэмэгдүүлэх.	Нэн шаардлагатай ном, хэвлэмэл бүтээгдэхүүний жагсаалтыг гаргаж, хүртээмжтэй болгон хөрвүүлэх ажлыг тасралтгүй зохион байгуулах	2025-2031	Нэн шаардлагатай ном, хэвлэмэл бүтээгдэхүүнийг хүртээмжтэй болгосон байна.	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Харилцаа холбооны зохицуулах хороо	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Төрийн бус байгууллага
73.	Улс төр, нийгмийн амьдралд оролцох (29 дүгээр зүйл) 58.а. Иргэний хууль болон Сонгуулийн тухай хуулийг	Холбогдох хууль тогтоомжид хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчид үзүүлэх дэмжлэгтэй холбоотой зохицуулалтыг тусгах	2025-2031	Холбогдох эрх зүйн баримт бичигт зохицуулалт нэмж тусгасан байна.	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хууль зүй, дотоод хэргийн яам,	Судлаачид, Төрийн бус байгууллага

Д/д	Конвенцын холбогдох зүйл, ирүүлсэн зөвлөмжийн дугаар	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хүрэх үр дүн	Хариуцан хэрэгжүүлэх байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
	Конвенцын заалттай уялдуулах үүднээс нэмэлт, өөрчлөлт оруулж, тэгш байдлыг хангах тусгай арга хэмжээ авч хэрэгжүүлэх, мөн Төлөөлөл багатай хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэр дундаа сонсголын, оюуны болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгуульт болон бусад албан тушаалд оролцоог дэмжихээс гадна хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчид, ялангуяа цөөнхийн улс төрийн намаас нэр дэвшигчид дэмжлэг үзүүлэх;				Сонгуулийн ерөнхий хороо	
74.	58.б. Сонгууль болон санал хураах журам, тоног төхөөрөмж, сонгуулийн цахим болон хэвлэмэл материалыг энгийн яриа хэлээр, хялбар уншигдах, ашиглах боломжтой болгож, улмаар хөгжлийн бэрхшээлтэй бүх хүмүүст хүргэх, хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг улс төрийн болон төрийн захиргааны төрийн өндөр албан тушаалд дэвшин ажиллахад шаардлагатай ур чадвар олгох хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2025-2031	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг улс төрийн болон төрийн захиргааны өндөр албан тушаалд дэвшин ажиллахад дэмжлэг үзүүлэх хөтөлбөр хэрэгжүүлсэн байна.	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Удирдлагын академи
75.		Улс төрийн намуудыг хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх ашгийг хамгаалах Төрийн бус байгууллагатай санал солилцох хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулах, санал зөвлөмж хүргэх, түүнийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	2025-2031	Сонгуулийн цахим болон хэвлэмэл материалыг энгийн яриа хэлээр, хялбар уншигдах, ашиглах боломжтой болсон байна.	Сонгуулийн ерөнхий хороо, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, улс төрийн намууд, Төрийн бус байгууллага
76.		Хөгжлийн бэрхшээлтэй иргэний сонгох эрхийг хангахтай холбоотой гарын авлага, зөвлөмж боловсруулан түгээх	2025-2031	Гарын авлага, зөвлөмж боловсруулж, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.	Сонгуулийн ерөнхий хороо, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Харилцаа холбооны зохицуулах хороо	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар, Төрийн бус байгууллага
77.	Хүмүүнлэгийн гамшиг болон эрсдэл бүхий нөхцөл байдал (11 дүгээр зүйл) 22.а. Хүмүүнлэгийн гамшиг болон эрсдэл бүхий нөхцөл байдлын талаарх үндэсний хууль тогтоомжийг хянан үзэж, хөгжлийн	Хөгжлийн бэрхшээлийг тэгш хамруулсан гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх	2025-2031	Төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлсэн байна.	Онцгой байдлын ерөнхий газар	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Төрийн бус байгууллага

Д/д	Конвенцын холбогдох зүйл, ирүүлсэн зөвлөмжийн дугаар	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хүрэх үр дүн	Хариуцан хэрэгжүүлэх байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
78.	бэрхшээлтэй хүмүүсийг хамгаалах заалтуудыг тусгах зорилгоор нэмэлт, өөрчлөлт оруулах, дохионы хэлний орчуулга, хялбар уншигдах зэргийг тусгасан хүртээмжтэй бөгөөд бүхний	Гамшгийн болон онцгой байдлын аврагчдыг хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй харилцах арга техник эзэмшүүлэх сургалтад тогтмол хамруулах	2025-2031	Албан хаагчид хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй харилцах арга техник эзэмшсэн байна.	Онцгой байдлын ерөнхий газар	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Төрийн бус байгууллага
79.	асуудлыг хамруулсан гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүд, сэтгэц-нийгмийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, оюуны бэрхшээлтэй хүмүүс, мэдрэхүйн бэрхшээлтэй хүмүүст зориулан батлан гаргах	Онцгой байдлын үед хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хувийн туслахын хамт үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэх	2025-2031	Эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна.	Онцгой байдлын ерөнхий газар, Хууль зүй, дотоод хэргийн яам	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Төрийн бус байгууллага
80.	асуудлыг хамруулсан гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, оюуны бэрхшээлтэй хүмүүс, мэдрэхүйн бэрхшээлтэй хүмүүст зориулан батлан гаргах	Онцгой байдал, гамшиг, ослын үеийн мэдээллийг хараа, сонсгол, оюун, сэтгэцийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй, хялбар уншигдах боломжтойгоор хүргэх	2025-2031	Мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.	Харилцаа холбооны зохицуулах хороо, Онцгой байдлын ерөнхий газар	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Төрийн бус байгууллага
81.		Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэнийг эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Би энд байна.” аяныг өрнүүлэх	2025-2027	Урьдчилан сэргийлэх аян өрнүүлсэн байна.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	Хууль зүй, дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Төрийн бус байгууллага